



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.10.25 № ЗТ-1/135
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



 П.ОЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.10.24 № ХЭГ/2024/9
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ⁴⁴ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000245018081

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 37 дугаар тэмдэглэлд:

“17.ХЭЛЭЛЦСЭН нь: Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2021.10.24 № 01/8801

танай _____-ны № _____-т

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД Ц.ТУВААН ТАНАА

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002844



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.10.24 № 1/1445
танай _____-ны № _____-т

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙД Ц.ТУВААН ТАНАА**

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.1} дэх хэсэгт зааснаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.



О.АЛТАНГЭРЭЛ

15160/07/1
Ав.Файл.2024



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.10.24 № 1/1444
танай _____-ны № _____-г

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙД Ц.ТУВААН ТАНАА**

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг
Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн
20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд
өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

151604071
А5.файл.2024

БАТЛАВ.

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС
БАЯЛГИЙН САЙД

Ц.ТУВААН

БАТЛАВ.

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр "... Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно" гэж байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчмыг баталгаажуулсан.

"Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь"-ийн 1.1.1-д "байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөж /татвар, ашиг гэх мэт/-ийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь Монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах" гэж заасан.

Энэ хүрээнд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр баталсан.

Тус хуульд Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хөгжлийн сан, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, хуваарилалт, хөрөнгийн удирдлагын талаар заасан. Тодруулбал, Ирээдүй өв санд улсын төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс төсвийн тогтворжуулалтын сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд нэн тэргүүнд хуваарилж, түүнээс үлдэх хэсгийн 65 хувийг, Хуримтлалын санд орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдийн нэгдэлд хамаарах уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хүртэлх

хувьцаанд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэн газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх ерөнхий зохицуулалтыг тусгасан.

Дээрх сангуудын эх үүсвэрийг бүрдүүлж байгаа стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, түүнийг орлуулан тооцох, түүнд нөөц ашигласны тусгай төлбөр тогтоохтой холбоотой асуудлыг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулсан боловч Цөмийн энергийн тухай хуульд эдгээр зохицуулалт тусгагдаагүй, тодорхойгүй байна.

Түүнчлэн дээрх Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1-д Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төслүүдийн “Цөмийн энергийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хэсэгт “Хуулийн зохицуулалтыг Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч байх зарчимд нийцүүлэх, Гадаад улсын цацраг идэвхт хаягдлыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглох зохицуулалтыг тусгах” чиглэлээр хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.2.2-т “Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа багц хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 3.3.1.11-д “Зөөвч-Овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулна” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлаас 2009 онд баталсан Цөмийн энергийн тухай хууль нь 8 бүлэг, 51 зүйлтэй бөгөөд нийт 15 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 8 бүлэг, 38 зүйлийн хэсэг, заалтад өөрчлөлт орсон байна.

Хууль хэрэгжсэн хугацаанд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцаанд гарсан томоохон өөрчлөлтүүдийг харгалзан холбогдох өөрчлөлтийг мөн хууль тогтоомжид оруулах шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 4.7-д “Цөмийн энергийн салбарт хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад энэ хуулийн 20 дугаар зүйл хамаарахгүй бөгөөд уг харилцааг Цөмийн энергийн тухай хуулиар зохицуулна.” гэж зааснаас үзэхэд Цөмийн энергийн тухай хуульд заасан татварын орчныг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан татварын орчин гэдгээр ойлгож болох эсэх нь тодорхойгүй байна. Энэхүү хууль эрх зүйн тодорхойгүй байдал нь Монгол Улсын Засгийн газар болон хөрөнгө оруулагч талаас энэ төрлийн ашигт малтмалыг ашиглах, хөрөнгө оруулалтыг татахад саад болж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт,

өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын дагуу байгалийн баялгийн үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

Түүнчлэн, Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу тогтворжуулахаас бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй гэж заасан. Үүнээс үзэхэд Татварын ерөнхий хуулиар Цөмийн энергийн хуулийн дагуу байгуулах хөрөнгө оруулалтын гэрээгээр татварыг тогтворжуулах асуудлыг тусгаагүй байгаагаас хууль хоорондын зөрчил үүсэх эрсдэлтэй байна. Түүнчлэн, татварын тогтворжуулалтын хамрах хүрээг Татварын ерөнхий хуулийн 4.1.1-д зөвхөн хувь хэмжээг гэж заасан бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.7, 20.4, Цөмийн энергийн тухай хуулийн 30.1.1-д зааснаар татварын орчин буюу татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг тогтворжуулахаар тус тус зөрүүтэй зохицуулсан байгааг уялдуулан тодорхой болгох шаардлагатай байна. Иймд татварын тогтворжуулалттай холбоотой эдгээр асуудлын хамрах хүрээг тодорхой болгох, хууль хоорондын нийцлийг хангуулах нь зүйтэй байна.

Иймд стратегийн ач холбогдол бүхий цацраг идэвхт ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн Монгол Улсын Засгийн газрын эзэмших хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулан тооцох, ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг тогтоох, зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тогтоох, хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа, цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд зэрэг асуудлыг тодорхой болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд стратегийн ач холбогдол бүхий цацраг идэвхт ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах үүднээс Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан цацраг идэвхт ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн Монгол Улсын Засгийн газрын эзэмших хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулан тооцох, зах зээлийн үнийн өсөлтөөс хамааран цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хувь, хэмжээг тогтоох, хөрөнгө оруулагчид үзүүлэх дэмжлэг болох тогтворжуулах татварын төрлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаа зэрэг эрх зүйн зохицуулалтыг тодорхой тусгах болно.

Дээр дурдсан хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа:

- Цацраг идэвхт хаягдал, цөмийн түлшийг Монгол Улсын хилээр оруулах, дамжин өнгөрүүлэхийг хориглох;

- Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болох;

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг төрийн дансанд байршуулах, холбогдох журмыг Засгийн газар батлах;

- Хөрөнгө оруулалтын гэрээг 10 хүртэл жилийн хугацаатай байгуулахаар заасныг 20 хүртэлх жил болгон өөрчлөх;

- Цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн ураны хүдрийн баяжмалын борлуулалтын үнэлгээний 5.0 хувь байх;

- Цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дээр 0-130 ам.доллороор ангилж, 0-9 хувь хүртэл нэмэгдүүлж тооцох

- Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан Улсын Их Хурал цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг өөрөөр тогтоох тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг тухайн ордын онцлог, ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшинг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоох.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засгийн дараах үр дагавар гарна гэж үзэж байна:

Цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа хангагдаж, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хүний эрүүл мэнд, нийгэм, байгаль орчныг хамгаалах нөхцөл бүрдэнэ.

Цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хөрөнгө оруулагчтай хамтран ашиглах тохиолдолд төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тодорхойлох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр, бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч нэмэгдүүлэн тооцох төлбөрийн зохицуулалтыг шинээр тусгаж, Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно..." гэж заасан нөхцөл хэрэгжих боломж бүрдэнэ.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал гарахгүй.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

---o0o---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.2.2, 3.3.1.11-т тус тус заасныг үндэслэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

1. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчмыг баталгаажуулсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1.1-д “байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөж /татвар, ашиг гэх мэт/-ийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь Монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах” гэж заасан байдаг.

Энэ хүрээнд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан.

Тус хуульд Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хөгжлийн сан, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, хуваарилалт, хөрөнгийн удирдлагын талаар заасан байдаг. Тодруулбал, Ирээдүй өв сан, төсвийн тогтворжуулалтын сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд улсын төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс нэн тэргүүнд хуваарилж, түүнээс үлдэх хэсгийн 65 хувийг, Хуримтлалын санд орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдийн нэгдэлд хамаарах уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хүртэлх хувьцаанд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэн газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх ерөнхий зохицуулалтыг тусгасан.

Дээрх сангуудын эх үүсвэрийг бүрдүүлж байгаа стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, түүнийг нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулан тооцохтой холбоотой асуудлыг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулсан байдаг боловч Цөмийн энергийн тухай хуульд эдгээр зохицуулалт тусгагдаагүй, тодорхойгүй орхигдсон байна.

Түүнчлэн дээрх “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1-д Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төслүүдийн “Цөмийн энергийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хэсэгт “Хуулийн зохицуулалтыг Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч байх зарчимд нийцүүлэх, Гадаад улсын цацраг идэвхт хаягдлыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглох зохицуулалтыг тусгах” чиглэлээр хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Түүнчлэн Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу тогтворжуулахаас бусад тохиолдолд Улсын Их Хурал татварыг зөвхөн татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй гэж заасан. Үүнээс үзэхэд Цөмийн энергийн хуулийн дагуу байгуулах хөрөнгө оруулалтын гэрээгээр татварыг тогтворжуулах асуудлыг Татварын ерөнхий хуульд тусгаагүй байгаагаас хууль хоорондын зөрчил үүсэх эрсдэлтэй байна. Татварын тогтворжуулалтын хамрах хүрээг Татварын ерөнхий хуулийн 4.1.1-д зөвхөн хувь хэмжээг гэж заасан бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.7, 20.4, Цөмийн энергийн тухай хуулийн 30.1.1-д татварын орчин буюу татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг тогтворжуулахаар тус тус зөрүүтэй зохицуулсан байгааг уялдуулан тодорхой болгох шаардлагатай байна. Иймд татварын тогтворжуулалттай холбоотой эдгээр асуудлын хамрах хүрээг тодорхой болгох, хууль хоорондын нийцлийг хангах нь зүйтэй байна.

Монгол Улсад цацраг идэвхит ашигт малтмалын 13 орд (Дорнод, Гурванбулаг, Улаан, Нэмэр, Мардайн гол, Хараат, Хайрхан, Гурвансайхан, Өлзийт, Дулаан-Уул, Зөөвч-Овоо, Энгэр ар, Далт)-ын хэмжээнд 192.2 мян.тонн геологийн нөөц бүртгэгдэж, үүнээс 11 ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэж авсан байна.

Улсын хэмжээнд 2024 оны 10 дугаар сарын байдлаар 4 аймгийн 9 сумын нутагт нийт 98.46 мянган гектар талбайд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын 3, ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийг 7 аж ахуйн нэгж эзэмшиж байгаа боловч өнөөгийн байдлаар олборлолт, баяжуулалтын амжилттай хэрэгжсэн төсөл байхгүй байгаагаас үзэхэд хууль эрх зүйн орчинд тодорхой өөрчлөлтүүдийг оруулах шаардлага үүссэнийг илтгэж байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлэд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно." гэж заасны дагуу хөрөнгө оруулагчтай хийх гэрээ хэлцлийн өмнө хууль эрх зүйн орчныг хуулийн дээрх

өөрчлөлттэй нийцүүлэх, хууль хоорондын уялдаа холбоог хангах зэрэг арга хэмжээг нэн яаралтай авах шаардлагатай байна.

Ингэснээр цацраг идэвхт ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалтын төслүүдэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татаж, олборлож, боловсруулах үйлдвэрүүдийг барьж ашиглалтад оруулснаар, экспортын орлого нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөг үзүүлэхээс гадна Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т заасан "баялгийн үр өгөөжийн дийлэнх нь Монголын ард түмэнд ногдох" шаардлага хангагдах боломж бүрдэх юм.

2. Олон улсын цацраг идэвхт ашигт малтмалын нөөц, олборлолт, үнэ, хэрэглээ, хэтийн төлөв ба сайн засаглалын туршлага

Олон Улсын Атомын энергийн агентлагийн (IAEA) ураны олборлолт, эрэлт, нийлүүлэлтийн талаар 2022 оны хэвлэлд мэдээлснээр дэлхийн хэмжээнд 6.1 сая тн ураны нөөц байна. Тус нөөцийн 93% нь 13 улсад тогтоогдсон ба Австрали Улс 1.6 сая тн, Казахстан Улс 906 мян.тн, Канад Улс 594 мян.тн ураны нөөцтэйгөөр тэргүүлж байгаа бол Монгол Улс 192,000 тн ураны нөөцөөр дэлхийн ураны нөөцийн 3 хувийг бүрдүүлж 10 дугаар байрт жагсаж байна.

Дээрх тайланд дурдсанаар 2022 оны байдлаар 15 орон 49'355 тн уран, үүний 56 хувийг газрын дор уусган олборлох аргаар, 38 хувийг уламжлалт уурхайн аргаар, 6 хувийг дайвар бүтээгдэхүүн хэлбэрээр тус тус олборлосон байна. Уг статистик мэдээллээр 2022 оны нийт олборлолтын 78 хувийг 4 улс буюу Казахстан (21'227 тн), Канад (7'351 тн), Намиби (5'613 тн), Австрали (4'553 тн) тус тус олборлоод байна.

Цөмийн эрчим хүчний салбарт хэрэглэх ураны хэрэгцээ 2024 онд 67'517 тн уран байгаа бол нүүрстөрөгчийн ялгарлыг тэглэх зорилтыг биелүүлэхийн тулд 2030 он гэхэд ураны эрэлт 83'840 тн болж 28 хувиар, 2040 он гэхэд 130'000 тн-д хүрч 2 дахин нэмэгдэх төлөвтэй байна.

Ойрын жилүүдэд бага оврын реактортой цөмийн цахилгаан станцын үйлдвэрлэл зах зээлд нэвтрэх боломжтой байгаа бөгөөд 2035 он гэхэд тус станцын зах зээл 21 ГВт хүрэх боломжтой гэж дээрх тайланд дурдсан байна.

Ураны уурхайнууд 2022 онд 49'355 тн уран нийлүүлсэн нь тухайн жилийн нийт хэрэгцээний 74%-ийг хангасан бол үлдсэн хувийг хоёрдогч эх үүсвэрээс бүрдүүлсэн.

Дэлхийн зах зээл дээрх ураны үнэ 2023 оны 01 дүгээр сард 49 ам.долл/фунт байсан бол 2024 оны мөн үед 106 ам.долл/фунт хүрч өссөн нь 2007 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт болсон байна. Өнөөгийн байдлаар ураны үнэ 83 ам.долл/фунт байна.

Олборлолтоор тэргүүлэгч Казахстан Улсын зарим ордуудын нөөц шавхагдаж байгаа, АНУ болон бусад 20 орчим улс 2050 он гэхэд цөмийн эрчим хүчээ 3 дахин нэмэгдүүлэхээ зарласан, Япон Улс цөмийн реактор барих төслийг дахин эхлүүлээд байгаа зэрэгтэй холбоотойгоор дэлхийн зах зээл дээрх ураны үнэ тогтвортой өсөх хандлагатай байна.

Нөөц баялаг, олборлолтоороо дэлхийд тэргүүлэгч 13 орны хувьд цацраг идэвхт ашигт малтмалын ордод төрийн оролцоог авч үзвэл цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, тусгай, өсөн нэмэгдэх төлбөр нь олборлолтын

хэмжээ болон үнээс хамааруулан дунджаар 3-10% байдаг ба хөрөнгө оруулалтын гэрээнд үндэслэж төрийн хувь, эзэмшлийн асуудлыг зохицуулж байна.

Тухайлбал, Дэлхийд ураны нөөцөөрөө 2-т (13 хувь), олборлолтоороо тэргүүлж буй Казахстан улс нь аж ахуй нэгжийн орлогын албан татварын хэмжээг 20 хувь, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн 6 хувиар тогтоосон байна. 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн зөвхөн 2025 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 9 хувь хүртэл нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. 2026 оноос хойш төлөх татварын хувь, хэмжээг олборлосон дүнгээс хамааруулан 4-18 хувь байхаар шийдвэрлэсэн байна. Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувьд тайлант хугацаанд ураны шар нунтаг (U3O8)-ийн үнэ тодорхой босго хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд 2026 оноос хойш татварын хувь хэмжээг 70\$/фунт – 0.5%, 80\$/фунт – 1%, 90\$/фунт – 1.5%, 100\$/фунт – 2%, 110\$/фунт – 2.5%-иар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн байна.

3. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага болон олон улсын сайн туршлагыг тандан судалсны үндсэн дээр хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг дараах байдлаар боловсруулав. Үүнд:

Хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1.1-д заасан “байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөж /татвар, ашиг гэх мэт/-ийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь Монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах” гэж заасны хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн харилцааг зохицуулахад оршино.

Цөмийн энергийн тухай хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа:

- Цацраг идэвхт хаягдал, цөмийн түлшийг Монгол Улсын хилээр оруулах, дамжин өнгөрүүлэхийг хориглох;

- Төрийн эзэмшлийн хувь хэмжээг стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болох;

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаа, хяналт мониторингод зарцуулах мөнгөн хөрөнгийг төрийн дансанд байршуулах, холбогдох журмыг Засгийн газар батлах;

- Хөрөнгө оруулалтын гэрээг 10 хүртэл жилийн хугацаатай байгуулахаар заасныг 20 хүртэлх жил болгон өөрчлөх;

- Цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн ураны хүдрийн баяжмалын борлуулалтын үнэлгээний 5.0 хувь байх;

- Цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дээр 0-130 ам.доллараар ангилж, 0-9 хувь хүртэл нэмэгдүүлж тооцох;

- Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан Улсын Их Хурал цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг өөрөөр тогтоох тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг тухайн ордын онцлог, ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшинг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоох.

Түүнчлэн, тус хуулийн төсөлтэй холбогдуулан Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулав.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хуулийн төсөлд хөрөнгө оруулалтын гэрээний хугацааг 20 жил хүртэл байгуулж болохоор заасантай холбогдуулан Татварын ерөнхий хуулиар Цөмийн энергийн хуулийн дагуу байгуулах хөрөнгө оруулалтын гэрээгээр татварыг тогтворжуулах асуудлыг тусгаагүй байгаагаас хууль хоорондын зөрчлийг арилгах хүрээнд "тогтворжуулах татварын орчин" гэх ойлголтыг тайлбарласан нэр томъёоны тодорхойлолтыг нэмж тусгав.

Үүнтэй холбоотойгоор Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын "төлөх татварын хувь, хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу тогтворжуулах" гэснийг "тогтворжуулах татварын орчныг Хөрөнгө оруулалтын тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу тогтоох;" гэж өөрчлөв.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт орсон холбогдуулан хууль хоорондын нийцлийг хангаж, "тогтворжуулах татварын орчин" гэх ойлголтыг тодруулан тусгав.

Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хууль батлагдсанаар цацраг идэвхит ашигт малтмалын төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зохицуулалт бий болсон тул компанийн энгийн хувьцааны талаарх холбогдох өөрчлөлтийг тусгав.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн талаар

Монгол Улсын Улсын Их Хурлын 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Цөмийн энергийн тухай хуулийг баталж, цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгаа гүнзгийрүүлэн судлах, түүнийг энхийн зорилгоор ашиглах, экспортлогч болох, улмаар цөмийн энергийг нийгэм, эдийн засгийн салбарт өргөн хүрээнд ашиглах, хүний эрүүл мэндэд халгүй, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй технологиор цөмийн эрчим хүч үйлдвэрлэх зэрэг зорилтыг дэвшүүлсэн.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “...Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчмыг баталгаажуулсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн “Цөмийн энергийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хэсэгт “Хуулийн зохицуулалтыг Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч байх зарчимд нийцүүлэх, Гадаад улсын цацраг идэвхт хаягдлыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглох зохицуулалтыг тусгах” чиглэлийг баримтлахыг даалгасан.

Түүнчлэн Цөмийн энергийн тухай хуулиар цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбоотой зарим харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулахаар заасан боловч цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой зохицуулалт нь тодорхойгүй, орхигдсон байна.

Мөн Татварын ерөнхий хуулиар Цөмийн энергийн хуулийн дагуу байгуулах хөрөнгө оруулалтын гэрээгээр татварыг тогтворжуулах асуудлыг тусгаагүй байгаагаас хууль хоорондын зөрчил үүсэх эрсдэлтэй байна. Түүнчлэн, татварын тогтворжуулалтын хамрах хүрээг Татварын ерөнхий хуулийн 4.1.1-д зөвхөн хувь хэмжээг гэж заасан бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.7, 20.4, Цөмийн энергийн тухай хуулийн 30.1.1-д зааснаар татварын орчин буюу татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг тогтворжуулахаар тус тус зөрүүтэй зохицуулсан байгааг уялдуулан тодорхой болгох шаардлагатай байна. Иймд татварын тогтворжуулалттай холбоотой эдгээр асуудлын хамрах хүрээг тодорхой болгох, хууль хоорондын нийцлийг хангуулах нь зүйтэй байна.

Иймд стратегийн ач холбогдол бүхий цацраг идэвхт ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн Монгол Улсын Засгийн газрын эзэмших хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулан тооцох, ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг тогтоох, зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тогтоох, хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа, цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд зэрэг асуудлыг тодорхой болгох зорилгоор хуулийн төслийг боловсрууллаа.

Дээр дурдсан хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа:

- Цацраг идэвхт хаягдал, цөмийн түлшийг Монгол Улсын хилээр оруулах, дамжин өнгөрүүлэхийг хориглох;

- Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болох;

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг төрийн дансанд байршуулах, холбогдох журмыг Засгийн газар батлах;

- Хөрөнгө оруулалтын гэрээг 10 хүртэл жилийн хугацаатай байгуулахаар заасныг 20 хүртэлх жил болгон өөрчлөх;

- Цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн ураны хүдрийн баяжмалын борлуулалтын үнэлгээний 5.0 хувь байх;

- Цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дээр 0-130 ам.доллараар ангилж, 0-9 хувь хүртэл нэмэгдүүлж тооцох;

- Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан Улсын Их Хурал цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг өөрөөр тогтоох тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг тухайн ордын онцлог, ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшинг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоох.

Түүнчлэн, тус хуулийн төсөлтэй холбогдуулан Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулав.

Иймд, энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасны дагуу үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялгийг олон улсын стандартын дагуу ашиглан хөгжүүлж, түүнээс олох орлогыг үндэсний эдийн засгийн бие даасан байдлыг

хангах, олон тулгуурт эдийн засгийг дэмжихэд чиглэх ач холбогдолтой тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр бэлтгэлээ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:

“4.2.Гадаад улсын цацраг идэвхт хаягдал, ашигласан цөмийн түлшийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглоно.”

2/8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт:

“8.1.4.Энэ хуулийн 5.4-т заасны дагуу Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар энэ хуулийн 5.2, 5.3-т заасан хувь хэмжээг тогтоох болон ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах эсэх асуудлыг шийдвэрлэх.”

3/9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт:

“9.1.9.Энэ хуулийн 5.4-т заасны дагуу энэ хуулийн 5.2, 5.3-т заасан хувь хэмжээг өөрөөр тогтоох, ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4/9 дүгээр зүйлийн 9.1.10 дахь заалт:

9.1.10.Цацраг идэвхт ашигт малтмалын ордын талбайн хил заагийг тогтоох.

5/20¹ дүгээр зүйл:

“20¹ дүгээр зүйл.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

20¹.1.Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч болон цацраг идэвхт ашигт малтмал экспортолсон этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байна.

20¹.2.Энэ хуулийн 20¹.1-д заасан төлбөр төлөгчийн экспортолсон, өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан тооцно.

20¹.3.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын үнэлгээний 5 хувиар ногдуулна.

20¹.4.Энэ хуулийн 20¹.3-д заасан хувь дээр цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч доор дурдсан хувийг нэмэгдүүлж тооцно:

Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллар/	Үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь
Уран	фунт	Ураны хүдрийн баяжмал (ураны исэл U ₃ O ₈)	0-50 хүртэл	0%
			50-60 хүртэл	1%
			60-70 хүртэл	2%
			70-80 хүртэл	3%
			80-90 хүртэл	4%
			90-100 хүртэл	5%
			100-110 хүртэл	6%
			110-120 хүртэл	7%
			120-130 хүртэл	8%
			130 ба түүнээс дээш	9%

20¹.5.Энэ хуулийн 5.4-т заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг энэ хуулийн 5.2, 5.3-т зааснаас өөрөөр тогтоосон бол төрийн эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно.

20¹.6.Энэ хуулийн 20¹.5-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээг тухайн ордын онцлог, ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшинг харгалзан тогтооно.

20¹.7.Энэ хуулийн 20¹.6-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

20¹.8.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөхөд Ашигт малтмалын тухай хуулийн 47.6-д заасны дагуу Засгийн газраас баталсан журмыг баримтална.

20¹.9.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл, тоо, хэмжээг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр худалдан борлуулж болох бөгөөд бүртгүүлсэн мэдээллийг татварын байгууллагад тухай бүр хүргүүлж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгэн адил төлж, тайлагнана.

20¹.10.Цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн, зах зээлийн үнийн эх сурвалжийн нэрийг Засгийн газар нийтэд зарлана.

20¹.11.Төлбөр төлөгч цацраг идэвхт ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан тухай бүр татварын хууль тогтоомжид заасан төлбөрийн баримт үйлдэх бөгөөд уг төлбөрийн баримтад цацраг идэвхт ашигт малтмалын тоо хэмжээ,

борлуулалтын үнэлгээ, ногдуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн дүнг тусгасан байна.

20¹.12.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.7.3-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг татварын албанаас баталсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор татварын албанд тус тус тайлагнана.

20¹.13.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.”

6/28 дугаар зүйлийн 28.2.12 дахь заалт:

“28.2.12.цацраг идэвхт ашигт малтмалыг хүдэр хэлбэрээр экспортлохгүй байх;”

7/30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг:

“30.4.Улсын Их Хурал энэ хуулийн 5.4-т заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх шийдвэрийг гаргасан тохиолдолд компанийн энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж болно.”

8/34 дүгээр зүйлийн 34.3-34.8 дахь хэсэг:

“34.3.Энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хүдрийн олборлолт, боловсруулалт, туршилтын үйл ажиллагаанаас үүссэн цацраг идэвхт хаягдлын менежментийг бүрэн гүйцэтгэх, олон улсын болон үндэсний дүрэм, журам, заавар, стандартад заасны дагуу аюулгүй үүрэгтэй.

34.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацраг идэвхт ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд дараах шаардлагыг биелүүлнэ:

34.4.1.цацрагийн хамгаалалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг улсын байцаагчаар хянуулж, батлан мөрдөх;

34.4.2.үйл ажиллагааны явцад гарсан осол, зөрчлийн талаар цөмийн болон цацрагийн хяналтын асуудал хариуцсан төрийн байгууллага, онцгой байдал, тагнуул, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдээлэх, ослын хор уршгийг арилгах, аюулгүй болгох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх;

34.4.3.Цөмийн энергийн комиссоос баталсан хөтөлбөрийн дагуу цацрагтай ажиллагчийг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах.

34.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг энэ хуулийн 34.6-д заасан журмын дагуу тооцож, төрийн дансанд байршуулна.

34.6. Мөнгөн хөрөнгө тооцоолох, байршуулах журмыг Засгийн газар батална.

34.7. Энэ хуулийн 15.2.2-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэр эхлэхээс өмнө уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулж, 5 жил тутам шинэчлэн цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах бөгөөд уурхай, үйлдвэрийг хаахаас 5-аас доошгүй жилийн өмнө хаалтын төлөвлөгөөг эцэслэн батлуулна.

34.8. Энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын нөхөн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу улсын төсөвт төлнө.”

2 дугаар зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсэгт “Төрийн эзэмшлийн хувь хэмжээг цацраг идэвхт ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэсэн өгүүлбэр, 12 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн “улсын ерөнхий” гэсний дараа “байцаагч, эсхүл ахлах” гэж, 20 дугаар зүйлийн заалтын 20.3 дахь хэсгийн “төлнө” гэсний өмнө “ногдуулан тайлагнаж, төсөвт” гэж, 28 дугаар зүйлийн 28.6.4 дэх заалтын “35.5,” гэсний дараа “35.11,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг:

“5.4. Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан энэ зүйлийн 5.2, 5.3-т заасан хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.”

2/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

“12.2. Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.5-д заасны дагуу олгож, цуцална.”

3/30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсэг:

“30.1.1. тогтворжуулах татварын орчныг тогтоох;”

4 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9.2 дахь заалтын “1-3” гэснийг “3” гэж, 20 дугаар зүйлийн заалтын 20.3.2 дахь заалтын “Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны” гэснийг “энэ хуулийн 20¹ дүгээр зүйлд” гэж, 28 дугаар зүйлийн 28.6.4 дэх заалтын “47.1, 47.5, 47.6, 48.7-48.10-т” гэснийг “48.7, 48.8-д” гэж, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “10” гэснийг “20” гэж гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.1.7. “тогтворжуулах татварын орчин” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.50-д заасныг.”

2 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “татварын орчныг тогтворжуулах” гэснийг “тогтворжуулах татварын орчныг тогтоох” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.50 дахь заалт нэмсүгэй:

“6.1.50."тогтворжуулах татварын орчин" гэж татварын хувь хэмжээ, элэгдэл, хорогдол тооцох хугацаа, татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацааг.”

2 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “төлөх татварын хувь, хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу тогтворжуулах;” гэснийг “тогтворжуулах татварын орчныг Хөрөнгө оруулалтын тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу тогтоох;” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсгийн “Энгийн” гэснийг “Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд энгийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулгын хавсралт

Улс орнуудын цацраг идэвхт ашигт малтмалын салбарт ногдуулах татварын хэмжээ

№	Улс орнууд, нөөц	Уран олборлолт, тонн /2022 оны байдлаар/	ААНОАТ	АМНАТ, %	Өсөн нэмэгдэх АМНАТ, %	Хууль, тогтоомж
1	Казахстан 815,200 тн, нийт нөөцийн 13%	21,227 21,100 тн /2023 оны байдлаар/	20%	2023.01.01-ээс эхлэн 6%-иар тогтоосон. 2025.01.01-ээс эхлэн зөвхөн 2025 онд холбогдох хувь хэмжээ 9% хүртэл нэмэгдэнэ. 2026 оноос хойш төлөх татварын хувь хэмжээ олборлосон дүнгээс хамаарна. 500 тн – 4% 1000 тн – 6% 2000 тн – 9% 3000 тн – 12% 4000 тн – 15% 4000-аас дээш – 18% байхаар Ерөнхийлөгчийн зарлиг гарсан.	Тайлант хугацаанд U ₃ O ₈ -ийн үнэ тодорхой босго хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд 2026 оноос хойш татварын хувь хэмжээ нэмэгдэнэ. 70\$/фунт – 0.5% 80\$/фунт – 1% 90\$/фунт – 1.5% 100\$/фунт – 2% 110\$/фунт – 2.5%	Газрын баялаг ашиглах тухай хууль, Татварын тухай хууль
2	Канад 588,500 тн, нийт нөөцийн 10%	7,351	Улсын төсөвт -15%, орон нутгийн төсөвт 8- 16%	Үндсэн металл, алмаз, уран зэрэг металл ашигт малтмал – Төлбөр төлөхөөс өмнөх уурхайн нийт орлогын 1%, Төлбөр төлсний дараах уурхайн нийт орлогын 1%, цэвэр орлогын 12% байна.	Эрдэс баялагийн татварын тухай хууль (1983), Орон нутгийн хууль болон борлуулалтын ашгаас хамаарна.	
3	Австрали 1,684,100 тн, нийт нөөцийн 28%	4,553	30% (Эргэлтийн хөрөнгө нь 50 сая австрали доллараас доош бол 25%-ийн татварын хөнгөлөлттэй)	Уран - 3.75% Ашигт малтмалын нөөц ашиглах 5.5 % 7.5% Буталсан бүтээгдэхүүн бол 5% Баяжмалд 2.5% металл, түүнтэй төстэй бүтээгдэхүүнд,	Татварын тухай хууль (Ашигт малтмалын нөөц ашигласны татвар), Уул уурхайн дүрэм, журам (1981)	

				Түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд тонн тутамд тогтоосон үнээр тооцдог.					
4	Нигер 311,100 тн, нийт нөөцийн 5%,	2,020	30% (25 сая нигерийн нариагийн орлоготой бол ААНОАТ-0%, 25-100 сая нигерийн нариа бол ААНОАТ-20%, түүнээс дээш бол том аж ахуй нэгж гэж үзэн 30%-ийн ААНОАТ ногдуулдаг)	Уран - 5,5% (Борлуулалтын ашгаас хамаарч 12-15% болгохоор ажиллаж байна.)	Үнд суурилсан нөөц ашигласны 0-10%-ийн төлбөрийг Нигерийн Хөрөнгө оруулалтын газарт төлөх ёстой.	Уул уурхайн тухай хууль (2006), борлуулалтын ашгаас хамаарч нэмэгдэнэ.			
5	Намиби 470,100 тн, нийт нөөцийн 8%	5,613	Уул уурхайн компани болон уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг компани 2024-2025 онд ногдох ААНОАТ-37.5% (Алмазанд 55%)	Уран - 3%, борлуулалтын орлогоос хамааран өснө.		Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 1981 онд батлагдсан Эрдэс баялгийн хуулиар зохицуулдаг.			
6	ОХУ 480,900 тн, нийт нөөцийн 8%	2,508	20% (Улсын төсөвт 2%, орон нутгийн төсөвт 18%)	/Зэс-8% Алт-6% Төмөр -4,8%/		Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, татварын тухай дүрэм, журам			
7	Узбекистан 131,300 тн, нийт нөөцийн 2%	3,300	15% (ААНОАТ-ийн хувь хэмжээг Татварын тухай хуульд өмнө жил нь ерөнхийлөгчийн зарлигаар тогтоодог)	Уран-8% /Байгалийн хий -10%, Алт-7% Зэс-7% Карбид-2.7% Нүүрс-4%/		2019.12.30-ны өдрөөс эхлэн мөрдөгдөж буй Татварын тухай хуулиар зохицуулагддаг. 2022.01.01-ээс эхлэн өөрчлөлт орсон.			
8	БНХАУ 223,900 нийт нөөцийн	1,700	25% (ААНОАТ-ийн тухай хуулийн дагуу стандарт татварын хувь хэмжээ)	3%		Татварын тухай хууль			

	4%			21% (2017.12.22-нд батлагдсан АНУ-ын татварын шинэчлэгдсэн хуулиар "дэлхий даяарх- татварын тогтолцооноос "нугаг дэвсгэр"-ийн татварын тогтолцоонд шилжиж, ААНОАТ-ын 35% хувь хэмжээг тогтмол 21% болгон бууруулсан)	Уран – Шинэ уурхай 4%, үйл ажиллагаагаа явуулж буй уурхай 8%	Уул уурхайн хууль, 1872 он
9	АНУ 59,400 нийт нөөцийн 1%	75	18% (ААНОАТ-ын стандарт 18%, 2024 оноос эхлэн банкуудын ААНОАТ-ийн хэмжээг 25% хүртэл нэмэгдүүлсэн) 27% (2023.03.31-ээс өмнө дуусгавар болох татварын жилүүдэд ААНОАТ-28, 2023.03.31-нээс хойш дуусгавар болох татварын жилүүдэд 27% болсон. Алт олборлож буй компаниудад татварын тусгай хувь хэмжээг тогтоодог бол бусад ашигт малтмалд жирийн ААН-д ногдуулдаг татварыг ногдуулдаг)	Уран - 5%	Уул уурхайн хууль 2017 он	
11	Өмнөд Африк 320,900 нийт нөөцийн 5%	200		Уран – Эхний 5 жилд 2%, Үүний дараа 5% (Боловсруулсан ашигт малтмалын АМНАТ 0.5-5%, Боловсруулаагүй ашигт малтмалын АМНАТ 0.5-7%)	Уул уурхайн хууль 1971 он, Уул уурхайн дүрэм журам 2011	

12	БНЭУ 292,867 тн	600	41.60-43.68% (Хуульд заасан гадны хөрөнгө оруулалттай ААН-ын суурь ААНОАТ-40%, мөн 4% хүртэлх эрүүл мэнд, боловсролын татварыг нэмдэг.)	Уран-6.6% (2021 онд АМНАТ-ийг эхний 4 жилд дотоодын борлуулалтын 4%, экспортын 7%, дараагийн 3 жилд дотоодын борлуулалтын 3%, экспортын 6% байх ёстой гэж зохицуулсан.)	(үнэ нэмэгдсэн 10%) өсөхөд үнийн	Ашигт малтмал, уул уурхайн хууль, 1957 он
13	БНЧУ 119,107 тн	193	21% (2024 оноос эхлэн ААНОАТ-21% болсон. Бүх ААН-д хамаарна. 2024 өмнөх нь 19%)	Уран – 0.3% (АМНАТ-ын 25%-ийг улсын төсөвт, 75%-ийг орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг.)		Уул уурхайн хууль, 1988 он 2006 онд шинэчлэгдсэн
14	Румын	50	16% Жижиг компани 60 мян.евро хүртэл-1%, 60 мян.еврогоос дээш-3%	Уран - 5% (Нийт үйлдвэрлэлийн үнийн дүнгийн 5%)		Эрдэс баялгын нөөцийн үндэсний агентлаг
15	Пакистан	45	29% Жижиг компани 20% (Мөн нийт орлогын хэмжээнээс хамаарч супер татвар нэмж ногдуулдаг. Үүнд: (Пакистан рупи) 150-200 сая - 1%, 200-250 сая - 2%, 250-300 сая - 3%, 300-350 сая - 4%, 350-400 сая - 6%, 450-500 сая - 8%, 500 саяас дээш - 10%).	Хөрөнгө оруулалт татаж байгаа тохиолдолд эхний 5 жилд АМНАТ-6.5%, 5 жилийн дараагаас аажмаар нэмэгдүүлнэ.		Татварын тухай хууль, Төлбөр хураамж, гаалийн тухай хууль
16	Бразил 276,800 нийт нөөцийн 5%	43	15% ААН-ийн орлого жилд 240,000 бразил реалаас давсан бол 10%-ийн татвар нэмж ногдуулдаг.	Ашигт малтмал 1 – 3.5%		Уул уурхайн тухай хууль (1967)

17	Иран	20	22.5% (ААНОАТ-ын стандарт хувь хэмжээ 25%)				
18	Малави 16,272 тн	0	35% (Уул уурхайн төслөөс хүү, роялти, ногдол ашиг зэргээс олсон орлогын 10%-аар нэмж татвар төлнө)	Уран – 5% (Австралийн Лотус компанитай 2024.08 сард байгуулсан улс ураны уурхай хөгжүүлэх гэрээнд Малави улс АМНАТ-5%, ААНОАТ-ыг 30% байхаар тогтоосон байна.)	Татварын тухай хууль		
19	ХБНГУ	0	30 – 33% (АМНАТ болон ногдол ашигийг эх үүсвэрээс нь суулган авч татвар ногдуулдаг. Корпорацийн татвар 15%+5.5%, худалдааны татвар 8.75 – 20.3% гэсэн 2 татвар ногдуулдаг. Хотуудаас шалтгаалан өөр өөр)	Ашигт малтмал – 0-40% (Уурхайн талбайн км.квадрат тугамд 5 евро)	Холбооны уул уурхайн хууль		
20	БНФУ	0	2020.01.01-ээс 31%, 2021.01.01-ээс 27.5%, 2022.01.01-ээс 25%	Ашигт малтмал - 33%	Татварын тухай хууль (7.63 сая еврогоос доош эргэлтийн хөрөнгөтэй бол эхний 38000 еврод 15%-ийн татварын хөнгөлөлт үзүүлнэ.		
Дундаж хэмжээ			27%	5%			
21	Монгол 192.241 тн Нийт нөөцийн 2%		10% эсвэл 25%	Нүүрс – 2.5% Алтнаас бусад – 5% /доод хэмжээ/	Ашигт малтмалын тухай хууль.		
	Нийт	49,355					
Ураны исэл (U ₃ O ₈)		58,201					

Эх сурвалж: <https://taxsummaries.pwc.com/france/corporate/taxes-on-corporate-income>

СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Дэлхийн ураны нөөц, уран олборлолтын талаарх мэдээлэл

Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА), Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын Цөмийн энергийн агентлаг хамтран 2 жил тутамд эрхлэн гаргадаг ураны олборлолт, эрэлт, нийлүүлэлтийн талаарх “Улаан ном” тайлангийн 2022 оны хэвлэлд нэг килограмм ураныг 260 хүртэлх ам.долларын өртгөөр олборлох боломжтой 8.0 сая тонн, 130 хүртэлх ам.долларын өртгөөр олборлох боломжтой 6.1 сая тонн ураны нөөц тус тус байна гэж бүртгэжээ.

Дэлхийд Австрали улс 1,692,700 тонн, Казахстан улс 906,800 тонн, Канад улс 594,900 тонн, ОХУ 486,000 тонн ураны нөөцтэйгөөр тэргүүлж байгаа бол доорх зурагт үзүүлсэн 16 орон нийт нөөцийн 95%-ийг бүрдүүлж, үлдэх 5% нь дэлхийн 20 улсад ногддог байна. Монгол улс 143,500 тн ураны (<USD130/kgU) нөөцөөр дэлхийн ураны нөөцийн 2%-ийг бүрдүүлж, 10-рт жагсаж байна.




Зураг 1. Дэлхийн ураны нөөцийн тархалт

Төмрийн хүдрээс бусад ашигт малтмалын геологи хайгуулын зардалд 2023 онд дэлхий даяар 12.7 тэрбум америк доллар зарцуулсан байна. Энэ зардлын 2% орчим буюу 250 сая ам.долларын хөрөнгийг ураны хайгуулд зарцуулжээ. Австрали, Канад, Хятад, Казахстан зэрэг оронд ураны хайгуулын ажилд нилээд хөрөнгө оруулалт хийгдсэн бол БНХАУ-ын төрийн өмчит CNNC компани 2021-2022 онд ураны хайгуулд 1,660,000 тууш метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэжээ. БНХАУ өөрийн дотоодын ураны хэрэгцээгээ хангахын тулд геологи хайгуулын ажлыг эрчимжүүлж Өвөр монгол, Шинжиан уйгурын нутагт хайгуул өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэж байна.

Дэлхийн дулаарал, хүлэмжийн хийн эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нэг чухал хэсэг нь цөмийн эрчим хүчийг хөгжүүлэх, ашиглах талаар дэлхийн улсууд бодлогын хувьд нэгдэн “ногоон эрчим хүч” хэмээн зарлаж байна. Цөмийн эрчим хүчний өсөлттэй холбоотойгоор дэлхийн зах зээлд ураны эрэлт хэрэгцээ 2035 он хүртэл 28 хувиар өсөх таамаглалыг олон улсын байгууллага, шинжээчид танилцуулж байна.

Ураны нөөц нь тогтоогдсон дэлхийн 40 орчим орон байгаагаас 2022 оны байдлаар 15 орон олборлолт явуулж 49,355 тонн уран (58,201 тонн U_3O_8) олборлосон бөгөөд БНХАУ дангаараа 21,227 тонн уран олборлож, дэлхийн ураны олборлолтод тэргүүлэх байр суурь эзэлсэн хэвээр байна. Нийт уран олборлолтын 78%-ийг 4 улс буюу БНХАУ (21,227 тонн-

43%), Канад (7,351 тонн-15%), Намиб (5,613 тонн-11%), Австрали (4,553-9%) улсууд тус тус олборлосон байна. 2023 оны ураны үйлдвэрлэлийн хэмжээ одоогоор баталгаажиг гараагүй байна.



Зураг 2. Дэлхийн уран олборлолтын хэмжээ

Ураныг уламжлалт уурхайн арга (ил, далд уурхай)-аар олборлож байсан боловч шинжлэх ухаан, технологийн дэвшилтэй уялдан уран олборлох технологид өөрчлөлт гарч, газрын дор уусган олборлох технологи үйлдвэрлэлд эрчимтэй нэвтэрч байна. 1990 онд нийт олборлосон ураны 55 хувийг далд уурхайн аргаар олборлож байсан бол 1999 онд 33%, 2000 оноос шинэ уурхайнууд ашиглалтад орсноор далд уурхайн олборлолт 40% болж өссөн. Газрын дор уусган олборлох арга нь 1960-аад оноос эрчимтэй хөгжиж эхэлсэн бөгөөд 2022 онд нийт ураны 56 хувийг тус аргаар, 38 хувийг уламжлалт уурхайн аргаар, үлдэх хэсгийг холимог металлын ордоос дайвар бүтээгдэхүүн хэлбэрээр олборлосон байна.



Зураг 3. Дэлхийн уран олборлолтын аргуудын өөрчлөлт (хувиар)

2022 оны байдлаар дэлхийн нийт уран олборлолтын 94%-ийг Казахстан, Канад, БНФУ, БНХАУ, ОХУ, Узбекистан, АНУ зэрэг 7 улсын дараах 10 компани бүрдүүлжээ.

Хүснэгт 1. Уран олборлолтоор тэргүүлэгч компаниуд

№	Компани	Улс	Уран (тонн)	Эзлэх хувь
1.	Казатомпром	БНКазУ	11,373	23
2.	Камеко	Канад	5,675	12
3.	Орано	БНФУ	5,519	11
4.	Си Жи Эн (CGN)	БНХАУ	4,627	10
5.	Ураниум Ван (Uranium One)	ОХУ	4,454	9
6.	Навой Майнинг	Узбекистан	3,300	7
7.	Си Эн Эн Си (CNNC)	БНХАУ	3,247	7
8.	Би Эйч Пи (BHP)	Австрали	2,813	6
9.	АРМЗ (ARMZ)	ОХУ	2,508	5
10.	Женерал Атомикс/Куазар	АНУ	1,740	4
11.	Бусад		4,098	6
	Нийт		49,355	100

2022 оны байдлаар нийт уран олборлолтын 57%-ийг дараах 5 улсын 10 уурхай бүрдүүлж байна.

Хүснэгт 2. Уран олборлолтоор тэргүүлэгч компаниуд (2022 оны байдлаар)

№	Уурхай	Улс	Эзэмшигч	Төрөл	Уран (тонн)	Эзлэх хувь
1	Cigar Lake	Канад	Камеко/Орано	Далд	6,928	14
2	Husab	Намиб	Swakop Uranium (CGN)	Ил	3,358	7
3	Inkai, талбай 1-3	Казахстан	Казатомпром/Камеко	ГДУО	3,201	7
4	Olympic Dam	Австрали	BHP Billiton	Дайвар/Далд	2,813	6
5	Budenovskoye 2	Казахстан	Kazatomprom/Uranium One	ГДУО	2,560	5
6	Rossing	Намиб	Rio Tinto	Ил	2,255	5
7	SOMAIR	Нигер	Orano	Ил	2,020	4
8	Four Mile	Австрали	Quasar	ГДУО	1,740	3
9	Central Mynkuduk	Казахстан	Ortalyk	ГДУО	1,650	3
10	South Inkai 4	Казахстан	Kazatomprom/Uranium One	ГДУО	1,600	3
Нийт					28,125	57%

2.1. Ураны үнэ

Ураны уурхайнууд 2022 онд 58,201 тонн шар нунтаг буюу 49,355 тонн уран нийлүүлсэн нь тухайн жилийн нийт хэрэгцээний 74%-ийг хангасан бол үлдсэн хувийг хоёрдогч эх үүсвэрээс бүрдүүлсэн. Хоёрдогч эх үүсвэр нь өмнө нь цэргийн зориулалттай хуучин материал байсан бол одоо 1990-2005 онд шавхагдаж дууссан уурхайн инженерийн байгууламжуудад хадгалагдаж буй хаягдал ураны овоолго бөгөөд 2022 оны эцсийн байдлаар Европт 36,000 тонн, АНУ-д 40,000 тонн, БНХАУ-д 132,000 тонн, Азийн бусад орнуудад 49,000 орчим тонн уран бүхий хаягдал овоолго байна гэж тооцоолсон байна.


Ураны эрэлтийн гол өсөлт нь ОХУ, БНХАУ бөгөөд Энэтхэг мөн байж болох юм. Дэлхийн цөмийн нийгэмлэгийн 2023 оны Цөмийн түлшний тайланд дурьдсанаар цөмийн эрчим хүчний реакторын хүчин чадлыг 18%-иар нэмэгдүүлэхэд 2023-2030 онд ураны эрэлт 28%-иар өсөх бол 2031-2040 онд 51%-иар өсөх хандлагатай байна. Гэхдээ эрэлт хэрэгцээ нь шинээр баригдаж буй реактор болон хуучин реакторуудын ашиглалтаас гарах хугацаанаас хамаарна. Цөмийн эрчим хүчний реакторын ашиглалтын хугацааг уртасгах, хуучин реакторуудыг үргэлжлүүлэн ажиллуулах нь эдийн засгийн хувьд сонирхол татахуйц байх бөгөөд дунд хугацааны ураны зах зээлд чухал хүчин зүйл болдог.

Олон улсын эрчим хүчний агентлагийн 2023 оны Дэлхийн эрчим хүчний төлөв байдлын тайланд үндэслэн 2040 он гэхэд цахилгаан эрчим хүчний хэрэгцээ 2022 онтой харьцуулахад 50% орчим өсөх хандлагатай байна. Дэлхий нийтээр нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулахтай холбоотойгоор дэлхийн цөмийн эрчим хүчний чадлыг нэмэгдүүлэх өргөн боломж байна¹. Түүнчлэн сэргээгдэх эрчим хүчийг цөмийн эрчим хүчтэй хослуулан ашиглах нь эрчим хүчний суурь ачааллыг даван туулах нэг арга зам болж байна.

Ураны үнэ 2024 оны эхээр нэг фунт нь 90 ам.доллар гаруй байсан нь 06 дугаар сарын 11-ний өдөр он гарснаас хойшхи хамгийн доод хэмжээнд буюу 82.80 ам.долларт хүрсэн. 2024 оны 10 дугаар сарын байдлаар 83.15 ам.доллар/фунт буюу 183.3 ам.доллар/кг байна. Хамгийн сүүлд АНУ болон бусад 20 орчим улс 2050 он гэхэд цөмийн эрчим хүчээ 3 дахин нэмэгдүүлэх төлөвлөгөөгөө зарласан. БНХАУ цөмийн эрчим хүчээр тэргүүлж, одоогоор дэлхий дээр баригдаж буй 59 реакторын 25-ыг нь барьж байгаа бол Япон улс цөмийн реактор барих төслийг дахин эхлүүлээд байна. Мөн энэ оны 05 дугаар сард ОХУ-ын цөмийн түлшний импортод АНУ хориг тавьсан нь дэлхийн цөмийн нийлүүлэлтийн сүлжээнд хэрхэн нөлөөлж болохыг хөрөнгө оруулагчид үнэлж, ажигласаар байна.


Хамгийн сүүлийн тооцооллоор дэлхийн цөмийн түлшний нийлүүлэлтийн тал хувийг, АНУ-ын ¼-ийг ОХУ хариуцдаг бөгөөд 2022 онд Украйнд довтолсон асуудлаас хойш Европын олон улс орнууд тус улсаас цөмийн түлш авахаас татгалзсан хэвээр байна.

¹ <https://world-nuclear.org/>



Зураг 4. Шар нунтагийн зах зээлийн болон урт хугацааны үнэ (2023 оны жилийн эцсийн сарын байдлаар)

Ураны түлшний эрэлтийг бусад ашигт малтмалын түүхий эдээс хамаагүй илүү урьдчилан таамаглах боломжтой. Ураны ихэнх нийлүүлэлт нь үйлдвэрлэгчидтэй 3-15 жилийн хугацаатай гэрээ байгуулснаар спот буюу зах зээлээс өндөр үнээр шууд худалдаалагддаг нь нийлүүлэлтийн аюулгүй байдлыг илэрхийлдэг.



Зураг 5. 2040 он хүртэлх ураны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал

Дэлхийн цөмийн нийгэмлэгийн мэдээлснээр цөмийн үйлдвэрүүдийн ураны хэрэгцээ 2024 онд 67,517 тонн уран байгаа бол улс орны засгийн газрууд нүүрстөрөгчийн ялгарлыг тэглэх зорилтыг биелүүлэхийн тулд цөмийн эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлснээр 2030 он гэхэд цөмийн реакторуудын ураны эрэлт 83,840 тонн буюу 28%-иар, 2040 он гэхэд 130,000 тонн буюу бараг 2 дахин нэмэгдэх төлөвтэй байна.

Барилгын бүтээц нь хялбар, хямд жижиг модуляр реакторууд мөн олны анхаарлыг татаж байна. Ойрын 5-10 жилийн хугацаанд бага дунд чадлын атомын цахилгаан станц (SMR)-ын үйлдвэрлэл зах зээлд нэвтрэх боломжтой байгаа бөгөөд 2035 он гэхэд SMR-ын нийт зах зээл 21 ГВт хүрэх боломжтой гэж үзэж байна.

Хоёр. Монгол Улсын ураны өнөөгийн нөөц, тусгай зөвшөөрөл

Монгол орны нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмалын 13 орд, 100 орчим илрэл, 1000 гаруй эрдэсжсэн цэг, цацраг идэвхт гажил илрүүлсэн. 2024 оны 10 дугаар сарын байдлаар Монгол Улсад ураны 13 ордын хэмжээнд 192,241.02 тонн геологийн нөөц бүртгэгдэж, үүнээс 11 ордын нөөцийг нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн бүртгэн авсан. 2020 оноос хойш өөрчлөлт ороогүй. Нийт нөөцийн 67% нь газар дор уусган олборлох аргаар ашиглахад тохиромжтой.

Хүснэгт 3. Монгол Улсын ураны ордууд, нөөц

№	Ордын нэр	Нөөцийн зэрэглэл	Ураны агуулга (%)	Нөөцийн хэмжээ (тонн)	Нөөц баталсан огноо	Тушаалын дугаар
1	Дорнод	C1+C2+ C1/бус/	0.18	27,221	1988.11.13	7, 3, 26, 2в-р хүдрийн биетүүд, ГКЗ СССР-ийн 1988/11/13 10538, 10412 дугаар тушаал
2	Гурванбулаг (төв хүдрийн биет)	B+C+C /бус/	0.152	13,058.3	2011.09.27	ЭБЭХ-ний сайдын 220 дугаар тушаал
3	Мардайн гол	C	0.052	1,948.1	2014.07.09	ЭБМЗ-ийн ХХ-12-10 тоот дүгнэлт
					2015.05.19	АМГ-ын даргын "Нөөц бүртгэх тухай" н/39 дугаар тушаал
4	Нэмэр	C	0.111	5,937.62	2014.07.09	ЭБМЗ-ийн ХХ-12-10 тоот дүгнэлт
					2015.05.19	АМГ-ын даргын "Нөөц бүртгэх тухай" н/39 дүгээр тушаал
5	Улаан	C1+C1 /бус/	0.145	270	1989.11.30	УАМНК-ын хурлаар хэлэлцүүлж бүртгүүлсэн 33 дугаар тогтоол.
6	Хараат	B+C	0.026	7,288	2009.10.16	ЭБЭХ-ний сайдын 288 дугаар тушаал
7	Хайрхан	B+C	0.071	8,406.5		
8	Гурвансайхан	C	0.034	4,250.1	2012.09.18	Уул уурхайн сайдын 13 дугаар тушаал
9	Өлзийт	C	0.036	3,075.7	2012.09.18	Уул уурхайн сайдын 13 дугаар тушаал
10	Дулаан-Уул	B+B/бус/+ C+C/бус/	217.69 г/тн	7,054.71	2011.08.23	ЭБЭХ-ний сайдын 192 дугаар тушаал
		B+B/бус/+ C+C/бус/	188.83 г/тн		4,841.73	2015.07.07
					2016.01.14	АМГ-ын даргын "Нөөц бүртгэх тухай" н/05 дугаар тушаал
11	Зөөвч-Овоо	B+B/бус/+ C+C/бус/	234 г/тн	93,290.63	2013.03.28	Уул уурхайн сайдын 70 дугаар тогтоолоор батлагдсан.
					2013.03.20	Уул уурхайн сайдын 76 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.
					2015.05.25	АМГ-ын даргын "Нөөц бүртгэх тухай" н/51 дүгээр тушаал
					2020.04.15	АМГТГ-ын даргын 2020.04.15 н/28-р тушаал
12	Энгэр ар	B+C	0.05	80.52	2016.08.01	АМГ-ын даргын "Нөөц бүртгэх тухай" н/88 дугаар тушаал
13	Далт	B+C	0.032	15,518.11	2018.12.08	АМГТГ-ын даргын "Нөөц бүртгэх тухай" н/123 дугаар тушаал
Нийт 192,241.02 тонн						

Монгол Улсын хэмжээнд 2024 оны 10 дугаар сарын байдлаар 4 аймгийн 9 сумын нутагт нийт 98.46 мянган гектар талбайд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын 3, ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийг 7 аж ахуйн нэгж эзэмшиж байна². Хайгуулын 2 тусгай зөвшөөрлийг Монгол улсын 100 хувийн хөрөнгө оруулалттай компани эзэмшдэг бол үлдсэн 1 хайгуулын зөвшөөрөл болон ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийг БНХАУ, БНФУ, БНЧУ, Япон зэрэг улсын хөрөнгө оруулалттай компаниуд эзэмшиж байна.

² Ашигт малтмал, газрын тосны газар



Зураг 6. Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өөрчлөлтийн мэдээлэл.

Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 0.06 хувийг эзэлж байна. 2009 онтой харьцуулахад хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо 13 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Гурав. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухай

Ураны нөөц болон олборлолтоор тэргүүлж буй зарим улс орнуудын ААНОАТ болон АМНАТ-ын хувь, хэмжээний талаарх товч судалгааг Цөмийн энергийн комиссын Ажлын албаас хийлээ.

Дэлхийн ураны нийт нөөцийн 28%-ийг дангаар бүрдүүлдэг Австрали Улс нь ААНОАТ-ыг 30%-аар тогтоожээ. Үүнд эргэлтийн хөрөнгө нь 50 сая австрали доллараас доош бол 25%-ийн татварын хөнгөлөлт үзүүлэхээр зохицуулсан байна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрыг 5.5 %, хүдэрт 7.5%, баяжмалд 5%, металл, түүнтэй төстэй бүтээгдэхүүнд 2.5%, түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд тонн тутамд тогтоосон үнээр тооцдог байна.

Дэлхийд ураны нөөцөөрөө 2-т (13%), олборлолтоороо тэргүүлж буй Казахстан улс нь аж, ахуй нэгжийн орлогын албан татварын хэмжээг 20%, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2023.01.01-ээс эхлэн 6%-иар тогтоосон байна. 2025.01.01-ээс эхлэн зөвхөн 2025 онд холбогдох хувь хэмжээнд АМНАТ-ыг 9% хүртэл нэмэгдэнэ. 2026 оноос хойш төлөх татварын хувь, хэмжээг олборлосон дүнгээс хамааруулан 500 тн-д 4%, 1000 тн-д 6%, 2000 тн-д 9%, 3000 тн-д 12%, 4000 тн-д 15%, 4000-аас дээш бол 18% байхаар Ерөнхийлөгчийн зарлиг гарсан. Өсөн нэмэгдэх АМНАТ-ын хувьд тайлант хугацаанд уран шар нунтаг (U3O8)-ийн үнэ тодорхой босго хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд 2026 оноос хойш татварын хувь хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн байна. Тухайлбал 70\$/фунт – 0.5%, 80\$/фунт – 1%, 90\$/фунт – 1.5%, 100\$/фунт – 2%, 110\$/фунт – 2.5% байна.

Канад Улс нь ураны нөөцийн 10%-ийг бүрдүүлдэг бөгөөд ААНОАТ нь улсын төсөвт 15%, орон нутгийн төсөвт 8-16% байна. Үндсэн металл, алмаз, уран зэрэг металл ашигт малтмалын хувьд АМНАТ нь төлбөр төлөхөөс өмнөх уурхайн нийт орлогын 1%, төлбөр төлсний дараах уурхайн нийт орлогын 1%, цэвэр ашгийн 12%-аар тооцдог байна.

Ураны нөөцийн 8%-ийг бүрдүүлдэг Намиби Улс нь 2024-2025 онд уул уурхайн компанид ногдох ААНОАТ-37.5%, алмаз олборлодог аж ахуй нэгжид 55% байхаар тогтоожээ. АМНАТ нь уран олборлодог аж ахуй нэгжид 3% бөгөөд борлуулалтын орлогоос хамааран өсөх төлөвтэй байна.

Нигер Улс нь ураны нөөцийн 5%-ийг бүрдүүлдэг, ААНОАТ нь 30% байдаг. Үүнд 25 сая нигерийн нариагийн орлоготой бол ААНОАТ-0%, 25-100 сая нигерийн нариа бол ААНОАТ-20%, түүнээс дээш бол том аж ахуй нэгж гэж үзэн 30%-ийн ААНОАТ ногдуулдаг. Мөн өсөн нэмэгдэх АМНАТ буюу зах зээлийн үнэд суурилсан нөөц ашигласны төлбөрийн

хувь хэмжээг 0-10%-аар тогтоож, Нигерийн Хөрөнгө оруулалтын газарт төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Ураны нөөц олборлолтоор дэлхийд тэргүүлэгч 15 орны ураны салбарын татварын зохицуулалтаас харахад цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь дунджаар 3-5% байгаа боловч аж ахуй нэгжийн үйл ажиллагааны орлогын албан татварын хэмжээ харьцангуй өндөр буюу дунджаар 25% байна.

Австрали, Нигер зэрэг улс нь ААНОАТ-ыг хамгийн өндөр буюу 30%-аар тогтоосон бол, АМНАТ-ийг Казахстан улс хамгийн өндөр буюу 6-9%-аар тогтоожээ. Мөн Казахстан болон Нигер улс нь өсөн нэмэгдэх татвар буюу зах зээлийн үнэд суурилсан нөөц ашигласны татварын хувь, хэмжээг тогтоосон байна.

Монгол Улс ААНОАТ-ыг 0-6 тэрбум төгрөгийн орлогод 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш орлогод 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулахаар хуульд заасан.

Харин ашигт малтмалын нөөц ашигласны суурь төлбөр, бүтээгдэхүүний үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь, төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр гэсэн байдлаар 3 ангилж байна.

Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж нь борлуулсан бүтээгдэхүүний үнийн дүнгийн 5-аас доошгүй хувиар тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөхөөр тусгагдсан.

Ашигт малтмалын тухай хуульд тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч суурь АМНАТ дээр өсөн нэмэгдэх татвар ногдуулах зохицуулалт оруулсан.

Харин Цөмийн энергийн тухай хуульд цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зохицуулалт тусгагдаагүй бөгөөд Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд ураны зах зээлийн үнийн түвшин, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувийг дараах байдлаар тооцоолсон.

Хүснэгт 1. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллар/	Үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь
Уран	фунт	Ураны хүдрийн баяжмал (ураны исэл U ₃ O ₈)	0-50 хүртэл	-
			50-60 хүртэл	1%
			60-70 хүртэл	2%
			70-80 хүртэл	3%
			80-90 хүртэл	4%
			90-100 хүртэл	5%
			100-110 хүртэл	6%
			110-120 хүртэл	7%
			120-130 хүртэл	8%
		130 ба түүнээс дээш	9%	

Мөн Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 34, 51 хувиас доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшихээр заасан байдаг. Мөн тус хуулийн 6 дугаар зүйлд Цацраг идэвхт ашигт малтмалын ордыг

хэмжээнээс нь үл хамааран стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ангилалд хамааруулна гэж заасан.

Ашигт малтмалын тухай хуулийн 47².2.Энэ хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална гэж заасан.

Харин Цөмийн энергийн тухай хуульд цацраг идэвхт ашигт малтмалын төрийн эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах тухай зохицуулалт тусгагдаагүй байна.

Иймд цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болох зохицуулалтыг Цөмийн энергийн тухай хуульд оруулах шаардлагатай байна.

---oOo---

**Улсын Их Хурлын байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд оролцох
Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн ажлын хэсгийн нэрс:**

1. Н.Учрал (Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга);
2. Д.Цолмон (Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга);
3. Д.Саруул (Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч);
4. Т.Ганбаатар (Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга);
5. Г.Намчинсүрэн (Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга);
6. Б.Тэлмүүн (Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга);
7. Л.Энх-Амгалан (Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга);
8. Ц.Уранчимэг (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого хэрэгжилтийн газрын дарга);
9. Г.Манлайжав (Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга);
10. Б.Баатарцогт (ЦЭК-ын Ажлын албаны Тамгын газрын дарга);
11. Э.Нямдаваа (Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга);
12. С.Наранцогт (Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал).